

**“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ****Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага****1.1. Хууль зүйн үндэслэл.**

Энэхүү тогтоолын төслийг дараах хууль, бодлогын баримт бичгүүдийг үндэслэн боловсруулсан болно:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.2.6, 3.3.2.11, 3.3.2.14 дэх заалтууд;
- Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5;
- Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгүүд.

1.2. Практик шаардлага

Монгол Улсын иргэний нисэхийн салбар Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ОУИНБ)-ын USOAP-CMA аудитад бага үнэлгээ авах, эсхүл ноцтой аюулгүй байдлын асуудал (significant safety concern)-тай гэж тодорхойлогдох эрсдэлтэй байна. Ийм тохиолдолд агаарын тээврийн салбар хэдэн тэрбум ам.долларын алдагдал хүлээж, асуудлыг залруулах, нөхөн сэргээхэд 10 жил хүртэл хугацаа шаардлага гарна. ОУИНБ-ын “Нисэх буудал, агаарын навигацгийн үйлчилгээний төлбөрийн бодлого” (Doc 9082)-д зааснаар хэлэлцэн тохиролцогч улс агаарын навигацгийн үйлчилгээний хураамжийг зохистой хэмжээнд тогтоож, нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд зарцуулах ёстой. Мөн Конвенцын Хавсралт 19 “Аюулгүй байдлын удирдлага”-ын 3.3-д хэлэлцэн тохиролцогч улс аюулгүй байдлын хяналтын мэргэшсэн, ур чадвартай ажилтныг тогтвортой ажиллуулах, цалин хөлс, нийгмийн баталгааг хангах үүрэгтэй гэж заасан. Иргэний нисэхийн тухай хуулийн дагуу:

- Агаарын навигацгийн үйлчилгээний хураамжийн орлогоор агаарын навигацгийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ (29.1);
- Хураамжийн орлого хүрэлцэхгүй тохиолдолд улсын төсвөөс санхүүжилт хуваарилна (29.2);
- Иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, осол зөрчлийн шалгалт нь олон улсын гэрээний хэрэгжилтийг хангахуйц санхүүгийн чадавхтай байх ёстой (49.1).

Ерөнхий сайдын 2025 оны 53 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн дүгнэлтээр, олон улсын гэрээ болон Иргэний нисэхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, агаарын навигацгийн үйлчилгээг аюулгүй, тасралтгүй явуулах, салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэхийн тулд

агаарын навигацийн хураамжийг улсын төсөвт төвлөрүүлэхийг зогсоож, иргэний нисэхийн салбарт бүрэн зарцуулах шаардлагатай. Энэ нь 2026 онд ОУИНБ-ын хийх нисэхийн аюулгүй байдлын бүрэн хэмжээний аудитад бэлтгэх, нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд чиглэнэ. Хоёр. Тогтоолын төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ Тогтоолын төсөл нь 3 зүйлтэй бөгөөд дараах асуудлыг зохицуулна:

1. Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогыг аюулгүй, тасралтгүй үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл, мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахад зарцуулж, олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах;

2. Нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтад шаардлагатай хүний нөөц, санхүүгийн чадавхийг бүрдүүлэх, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсанаас үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Тогтоолын төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн бий болно:

1. ОУИНБ-ын USOAP-CMA аудитад бага үнэлгээ авах, ноцтой аюулгүй байдлын асуудал тодорхойлогдох эрсдлээс зайлсхийж, хэдэн тэрбум ам.долларын алдагдал, 10 хүртэл жилийн нөхөн сэргээлтийн хугацаанаас сэргийлнэ.
2. Олон улсын гэрээ, Иргэний нисэхийн тухай хуультай зөрчилдөж буй асуудлыг шийдвэрлэж, 15-аас дээш жилийн насжилттай (70 гаруй хувь) навигацийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, мэргэшсэн хүний нөөцийн хомсдлыг арилгана.
3. ОУИНБ-ын урьдчилсан шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлж, тоног төхөөрөмжийн шинэчлэл, хяналтын байцаагчийн орон тоог нэмэгдүүлэх, сургалтыг сайжруулах, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах зэрэг арга хэмжээг авна.
4. Агаарын навигацийн үйлчилгээг сайжруулах, бүсийн нислэгийн удирдлагын нөөц төв байгуулах, дүрэм журмыг шинэчлэх, нисгэгч, инженер, техникийн ажилтнууд, хяналтын байцаагч нарыг сургах, чадавхжуулахад шаардлагатай санхүүгийн боломж бүрдэнэ.
5. 2026 оны ОУИНБ-ын аудитад амжилттай хамрагдаж, иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлын түвшинг дэлхийд баталгаажуулна.

Дөрөв. Тогтоолын төслийн Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай уялдаа

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоолуудтай бүрэн нийцсэн. Тогтоол батлагдсанаар бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хүчингүй болгох шаардлагагүй.

--- oOo ---